



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 08 сарын 25 өдөр

Дугаар А/37

Өвт

Шууд гэрээ байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахьхэсэг, Засгийн газрын 2021 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засаг даргын Тамгын газар өнгөт принтер нийлүүлэх ажлыг “Писимолл” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай шууд гэрээ байгуулах аргаар гүйцэтгүүлсүгэй.

2. “Писимолл” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай гэрээ байгуулан, акт үйлдэн хүлээн авахыг Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албаны дарга (О.Отгонтуяа)-д даалгасугай.

3. Зардалд шаардагдах 685,900 (зургаан зуун наян таван мянга есөн зуун) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын багаж, техник хэрэгслийн зардлаас зарцуулахыг Санхүүгийн албаны нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

4. Өнгөт принтерийг Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэн, холбогдох албан хаагчид хүлээлгэн өгөх ажлыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д даалгасугай.

ДАРГА

Н.БАТ-ЭРДЭНЭ